

ОРЧИН ҮЕИЙН СОНИНЫ ЯРИЛЦЛАГА  
ОЛОН НИЙТИЙН СЭТГЭЛ ЗҮЙД НӨЛӨӨЛӨХ НЬ

Х. Энхтуяа\*

\* «Отгонтэнгэр» их сургууль, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, докторант

**Түлхүүр үг:** сэтгүүл зүй, сонин, ярилцлага, сэдэв, гарчиг, асуулт, эрх чөлөө, ардчилал, нийгмийн харилцаа, улс төрийн төлөвшил, манлайлал, итгэл үнэмшил, даган дуурайх, ижилсэх хандлага, мэдээллийн соёл

**М**онгол оронд нийгмийн мэдээллийн харилцааны чухал хэлбэр сэтгүүл зүй үүссэнээс хойш 100 жил өнгөрчээ. Энэ хугацаанд сэтгүүл зүй нь Монголын хөгжил дэвшлийн гэрч, хүн ардын ухамсар, оюун сэтгэлгээний өсөлтийг илтгэх он дарааллын бичиг болж ирлээ.

Монголын сэтгүүл зүй өнгөрсөн хугацаанд ээдрээтэй замыг туулж, арвин туршлага хуримтлуулж, арга барилаа шинэчлэн боловсруулсаар байна. XX зууны Монголын нийгэм-улс төрийн нарийн түвэгтэй үйл явц, гадаад дотоод байдал, бүтээн байгуулж, гэгээрч соёлжиход тохиолдсон бэрхшээл хүндрэл зэрэг нь XXI зууны сэтгүүл зүйн түүхийг баяжуулж, арга барилыг боловсронгуй болгоход нөлөөлжээ.

Дурдсан бүхий хугацаанд олон түмнийг нийгмийн чухал мэдээллээр хангаж, харилцуулах дэвшилтэт аргыг

үйл ажиллагаандаа нэвтрүүлж, нийтлэл, нэвтрүүлгийн төрөл зүйлийг бүрэн эзэмшиж, сэтгүүл зүйн өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас суралцаж, шинэ сэтгүүл зүйг эрчимтэй хөгжүүлж байгаа нь Монголын сэтгүүл зүйн чухал ололт юм.

Өдгөө ОНМХ-ийн хөгжил дэвшил хамгийн хурдацтай, сонирхолтой үедээ явж байна. Олон нийтийн мэдээллийг дамжуулагч нэгэн чухал хэрэгсэл нь яах аргагүй сонин мөн. 2013 оны эхний байдлаар манай улсад 555 хэвлэл мэдээллийн байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас 135 нь сонин байгааг МХХ-ийн Мониторингийн судалгаанд дурдсан байна<sup>1</sup>. Сонины тухайд өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад борлуулалтын тоо эрс өсч, 25,8 саяд хүрчээ. Энэ нь давтамж ойр сонинууд болох өдөр тутмын, 2-3 хоног тутмын хийгээд долоо хоног тутмын сонин тоо нэмэгдсэнтэй холбоотой. Өдөр тутмын сонин борлуулалт өмнөх оноос 1.5 хувиар өсч, сонин борлуулалтын зах зээлийн 73 хувийг эзэлж байна.

Тогтмол хэвлэлийн нийтлэлийн хамгийн гол, хамгийн түгээмэл бичлэгийн төрөл зүйлийн нэг нь одоо нэгэнт

ярилцлага болжээ. Ярилцлага хийх арга хэлбэр улам нарийсан хөгжсөн байна. Тиймээс сүүлийн жилүүдэд сонины бичлэгийн төрөл зүйл, тэр дотор ярилцлага сэтгүүлчдийн төдийгүй, судлаачдын анхаарлыг ихээхэн татаж, янз бүрийн түвшинд зохих судалгааны ажлууд хийгдэж байна.

Орчин үеийн сонины ярилцлагын талаар, тэр тусмаа ярилцлага олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлж байгаа талаар авч үзэхээс өмнө Монголын сэтгүүл зүй дэх ярилцлагын үүсэл хөгжлийг тоймлон өгүүлье.

**С**этгүүл зүй нь сурвалжлагаас, сурвалжлага нь ярилцахаас эхэлдэг. Ярилцлага нь сэтгүүл зүй үүсэхээс өмнө байсан утга зохиолын нэг хэлбэр бөгөөд шуурхай мэдээлэл түгээдэг сонин анх үүсэхдээ түүнийг өвлөн авч өөрийн хуудсанд баяжуулан хөгжүүлж иржээ. Энэ жишгээр 1913 онд Монголын анхны сонин «Шинэ толь хэмээх бичиг» гарангуутаа л ярилцлагын элементтэй зүйл нийтэлж эхэлсэн байна. Тус сонины сүүлчийн дөрвөн дугаарыг дамжин нийтлэгдсэн «Их ноён Хуучин, мэргэн багш Ёст, орос Магад, хятад Ёслол нар ажиггүйн оронд зөвлөн тэмцсэн дөрвөн замын уулзвар нь»<sup>2</sup> гэдэг нийтлэл бол ярилцлагыг сэтгүүл зүйн мэдээллийн зорилгоор сонин сэтгүүлд хэрэглэсэн анхны оролдлогуудын нэг болсон юм. Шинийн нэгэнд уулзан золгож, идээ зоог барих зуур ноён, лам, орос, хятад дөрвөн хүн цаг төрийн байдлыг хүүрнэн ярилцсан хэлбэртэй энэ бичлэг Орос, Хятад, Монгол гурван улсын харилцааны эмзэг асуудлыг хөндөж, тэдгээр улсын ихэс дээдсийн дургүйцлийг төрүүлж, улмаар сонины гаралтыг зогсоох шалтгаан болсон байна.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа гарч байсан хувьсгалт хэвлэлүүдэд сонины сурвалжлагч хэн нэг хүнд асуулт тавьж хариу авах харилцан ярианы хэлбэрээр нийтлэл бичих аргуудыг өргөн хэрэглэж байжээ.

Монголын тогтмол хэвлэлд 30, 40-өөд оноос ярилцлага элбэгшсэн бөгөөд энэ нь цаг үеийн байдал, олон түмний мэдээллийн эрэлтээс урган гарсан байна. Ярилцлага анхандаа зохиогч өөрийн санааг өөр хүмүүс ярилцаж байгаа байдлаар илэрхийлэх арга байсан бол 30-аад оноос бодитой явдал, ажил хэргийн талаар тодорхой бие хүмүүсийн хооронд өрнөсөн ярианы тэмдэглэл болж, мэдээлэх шинж нь давамгайлж иржээ.

30, 40-өөд оны ярилцлага олон улсын харилцааны асуудлаар зонхилон гардаг, гадаадын улс төрийн сэдэвтэй, ганцаарчилсан ярианы хэлбэртэй байснаа улмаар дотоодод болж байгаа улс төрийн чухал үйл явдалд ханддаг болж, хүн ардын бүтээн байгуулах их үйлсийн ололт амжилт, хөдөлмөрийн тэргүүний хүмүүсийн ажил үйлс, санаа зоригийг илэрхийлж, улс орон хөгжихөд саад тотгор бологч ажлын дутагдал, хүнд суртлыг шүүмжлэх нэлээд боловсронгуй шатанд хүрсэн байна. Ярилцлагын гарчиг гэхээр зүйл байхгүй, зөвхөн ямар нэгэн сайд, дарга, гаднын улсын эрх мэдэлтэн сурвалжлагчийн тавьсан нэг л ерөнхий асуултад өгсөн хариулт гэдэг нэрийн дор хэвлэгддэг байснаас харахад ярилцлага зөвхөн өндөр албан тушаалтан, эрх мэдэлтний ажлын тайлан маягаар олон түмэнд тулган хүргэдэг мэдээлэл байжээ. Сурвалжлагчийн хувьд олон асуулт тавих эрхгүй, ярилцагч, сурвалжлагч аль аль

нь өөрийн үзэл бодлыг илэрхийлэх боломжгүй, нэлээд албархуу байсан байна.

50-иад оны үеэс ярилцлагын сэдэв тэлж, асуудал дэвшүүлэх, санал солилцох, туршлага дэлгэрүүлэх чиглэлтэй болж ирсэн нь энэ зүйлийн хөгжилд чухал алхам болжээ. Энэ үеэс сэтгүүлч, ярилцагчдаа илүү олон асуулт тавьж, хэрэгтэй мэдээллээ авч, яриаг залж хөтлөх, өөрөөр хэлбэл сэтгүүлчийн оролцоо нэмэгдэх эхлэл тавигдсан байна. Хэлбэрийн хувьд харилцан яриа маягтай болж, гарчгийн хувьд ерөнхий агуулгаараа бичигдэж байв.

60-аад оноос ярилцлагын хэлбэрт өөрчлөлт орж бүлэг хүмүүстэй уулзаж ярилцан, бичлэгийг буулгахдаа өмнө нь хөтөч оруулж, протокол хэлбэрээр бичиж байсан байна. Сэдвийн хувьд ажил амьдралын гүн рүү улам ойртуулж Монголын хөрсөнд буулгах болжээ. Ярилцагчийн хувьд ч, сурвалжлагчийн хувьд ч тодорхой хэмжээгээр өөрийн үзэл бодол, сонирхлыг тусгах хандлага гарч ирсэн байна. Гарчиг нь хэнээс хэнтэй юуны тухай ярилцсаныг мэдээлсэн шинжтэй байв.

Дээрх хугацаанд ярилцлага нь сонины хуудсанд тийм ч түгээмэл бичлэгийн төрөл зүйл байгаагүй юм.

70-аад оноос сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийн нэг болохын хувьд ярилцлага хэмээн нэрлэгдэх болж, түүний олон хэлбэр төлөвшин бүрдэж,

хэвлэлийн хуудсанд харьцангуй элбэг үзэгдэх болжээ. Ярилцлагын гарчиг нь ярилцсан сэдвийн нэр шинжтэй болж, ганц үгээс хүртэл бүтсэн хийсвэр утга илэрхийлэх болсон байна. Гэсэн хэдий ч сурвалжлагч, ярилцагч хоёр өөрийнхөө үзэл бодол, дотоод мөн чанарыг илэрхийлж ойлголцох байдал хязгаарлагдмал байв.

80-аад оны үеийн тогтмол хэвлэлд ярилцлага нэр томъёоны хувьд нэг мөр болж, сэдвийн хүрээ өргөжиж, хэлбэрийн хувьд улам баяжиж, аль ч сонинд харьцангуй түгээмэл нийтлэгддэг болжээ<sup>3</sup>. Зөвхөн төвийн нийгэм-улс төрийн томоохон сонинд ярилцлага нийтлэгддэг байсан

бол орон нутгийн сонинд гарч эхэлсэн давуу талтай байв. Гэхдээ 90-ээд онтой харьцуулахад тооны хувьд цөөн, сэдвийн хувьд явцуу, нэлээд албархуу шинжтэй, ярилцагчид нь ихэнх тохиолдолд албан тушаалтнууд байж, нэг хэв загварын зохиомж, бичлэгийн арга хэлбэр зонхилж байжээ.

Ярилцлага нь 90-ээд оноос цоо шинэ өнгө аясыг олж, сэтгүүл зүйн хамгийн түгээмэл, шуурхай, бас хүртээмжтэй зүйлийн нэг болон хувирсан байна. Энэ үеэс хойш зах зээлийн хатуу ширүүн шуургыг сөрөн тэсвэртэйгээр даван туулж, улмаар идэвхтэй хөгжиж яваа энэ үед сэтгүүлчид чөлөөтэй сэтгэж бодох, уран бүтээлийн эрэл хайгуул хийх бололцоо бий болжээ. Ярилцлага

«

*Ярилцлага нь 90-ээд оноос шинэ өнгө аясыг олж, сэтгүүл зүйн хамгийн түгээмэл, шуурхай, бас хүртээмжтэй зүйлийн нэг болжээ. Зах зээлийн хатуу ширүүн шуургыг сөрөн тэсвэртэйгээр даван туулж, улмаар идэвхтэй хөгжиж яваа энэ үед сэтгүүлчид чөлөөтэй сэтгэж бодох, уран бүтээлийн эрэл хайгуул хийх бололцоо бий болсон байна.*

»

бичих ур чадварт арга хэлбэрийн өөрчлөлтүүд гарч, агуулгын хувьд мэдээлсэн, асуудал дэвшүүлсэн, хөрөглөсөн, зураглалтай, чөлөөт хэлбэрийн ярилцлагууд түгээмэл нийтлэгдэх болсон байна.

Сэтгүүлч ярилцлагаар дамжуулан мэдээлэл хүргэхээс гадна, уншигчийн алжаалыг тайлж, зугаацуулахыг зорьдог болов. Ярилцлагын гол зорилго нь баримт, үйл явдлыг уншигчдад үнэн зөв мэдээлэх, батлах, нийгмийн амьдралын зангилаа асуудлаар олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх явдал гэж тодорхойлох болжээ.

Орчин үеийн нийгмийг төлөвшүүлэгч соёлын хэм хэмжээ, үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх үүргийг сэтгүүлчид гүйцэтгэж байгаа бөгөөд тэд өнөөдөр зөвхөн мэдээлэл түгээгчид бус, нийгмийн санаа бодлыг бүрдүүлэгчид болоод байгаа билээ. Өнөөдрийн Монголын иргэний нийгмийн төлөвшилд чухал нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл нь яах аргагүй олон нийтийн мэдээлэл харилцааны хэрэгсэл юм.

Чөлөөт өрсөлдөөн, хувь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэнээр засаглалын төв нь төр засаг биш, ард түмний эрх ашиг гэдгийг ухамсарлуулан, **хэлэх юмтай хүн болгон өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөг сонины ярилцлагаар дамжуулан эдлэх болжээ.**

Хэвлэлээр дамжуулан өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх нь олон нийтийн үзэл бодлыг төлөвшүүлэхэд нөлөөлөх, төр засгийн байгууллагуудын зүгээс зөрчил гаргах, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэхийн эсрэг зогсох, хяналт тавих хэрэгсэл болж эхэлж байна.

Германы философич, экзистенциалист К.Ясперс «Би»-гийн ухамсрыг өөр лүү нь бусад экзистенцитэй хамаарах байдал (коммуникаци) руу нь хандуулж, хүмүүс хоорондын хамаарал (коммуникаци)-ыг чухалчлан тайлбарладаг. Үүнд: хүнийг салангид ганц бодгаль маягаар ойлгох явдал буруу. Бодгаль хүмүүсийн хамаарал бол тэдний *ахуйн урьдчилсан нөхцөл* юм. Бид бие биеэ харилцан *ухамсартайгаар* ойлгодгийнхоо ачаар бид болцгоодог. Харилцан хамаардаг шинж, нөгөөдөө хамааруулж болох тийм зүйл бол үнэн мөн»<sup>4</sup> гэж тайлбарласан байдаг. Энэхүү фиолосийн үзэл орчин үеийн сонины ярилцлагаар дамжин биеллээ олж байгааг бид харж байна. Олонхийн төлөөлөл болон бие хүн жинхэнэ *өөрийнхөө мөн чанарыг ойлголцох хамгийн шилдэг арга* нь сурвалжлагчтай хийсэн ярилцлага болжээ.

**С**этгүүлч өөрийн авьяас, ур чадварын үр дүнд ярилцагчийнхаа оюун санааны мухрыг ухаж, бүтээж туурвих хүч чадлыг ил гарган түүний өөрийгөө илэрхийлэх голч чанарыг бий болгож байна. Хүн ямагт өөрийгөө илэрхийлэхийг хүсч байдаг бөгөөд энэ хүслийг биелүүлэх боломжийг бидэнд өнөөдрийн ардчилсан нийгэм, түүний дотор чөлөөт хэвлэл олгож байгаа билээ.

Нийгмийн харилцааны үйл явц олонхийн хэлбэрт шилжиж, хувь хүн ярилцлагаар дамжуулан олонход хандах боломжтой болсноор түүний зүгээс хүрээлэн буй байгаль орчин, нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын харилцаанд нөлөөлөх үр нөлөө нэмэгдэж, олон түмний амьдралын хэв маягт өөрчлөлтийг авч ирсээр байна.

Өөрөөр хэлбэл хэвлэлийн ярилцлага нь хүний амьдралаас салгаж болшгүй нэг зүйл болж, улс төрийн төлөвшил, манлайлал, итгэл үнэмшлийг бий болгож, даган дуурайх, ижилсэх хандлагыг ч бий болгоход чухал үүрэг гүйцэтгэх болжээ.

Орчин үеийн сонины ярилцлага нь нийгмийн тодорхой хүрээлэл, давхаргын төлөөлөл болон хувь хүнд:

1) иргэний нийгмийн бүхий л бүтэц, нэгжийн эрх ашгийг илэрхийлэх,

2) тэдний дотоод сэтгэлийн үнэ цэн, оюуны цар хүрээг нийгэмд таниулах,

3) тодорхой нийгмийн харилцааны дотор, шаардлагатай тохиолдолд эсэргүүцлийг сөрж байж өөрийн санаа зоригийг хэрэгжүүлэх, тулган хүлээлгэх,

4) төр засгийн засгийн бодлого шийдвэр, бусдын үзэл бодлыг шүүмжлэх, тэдэнд асуулт тавих,

5) бусад бүлэг, этгээдтэй хамтран ажиллах,

6) нийгэм дэх хүчнүүдийн тэнцвэрт байдлыг хангах,

7) нэр хүндийн шинэ бодит дүр төрхийг бий болгох,

8) засаглалын төвлөрлийг сааруулах замаар түүний хүч нөлөөг багасгах зэрэг олон боломжийг бүрдүүлж өгч байна.

Олон түмэн мэдээллийн эргэлтэнд анхаарах болж, ярилцлага өөрөө *мэдээллийн соёл* гэдэг зүйлийг бий болгож байна. Үүнд сэтгүүлчийн болон ярилцагчийн ёс суртахууны хэм хэмжээ, хүн чанар, хувь хүний онцлог, мэдлэг, чадвар, мэдээллийн чанар, үнэн бодит байдал, үр нөлөө-ач холбогдол оршино.

Хүн амьдралд нь тохиолдож буй асуудал, бэрхшээлийг хэвлэлийн

ярилцлага, мэдээллээр дамжуулан олж харж шийдвэрлэх гэж хичээн тэмүүлдэг болсон байна.

Өмнөх нийгэмд "төр засгийн бодлогыг мэдээлэлжүүлэх" ойлголт байсан бол одоо түүний хамтаар "мэдээллийг бодлогожуулах" ойлголт нэвтэрч, нийгмийн өөрчлөлт нь улс төрийг мэдээлэлжүүлэх, хэвлэл мэдээллийг улс төржүүлэх гэсэн нэгдмэл хоёр үйл явцыг нэгэн зэрэг агуулж өрнөн, сэтгүүлчийн мэргэжлийн агуулгыг өөрчлөхөд нөлөөлж эхэллээ. Энэ нь нийгмийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, хүлээн авагчид ч улс төржсөн мэдээлэл, ярилцлагаар "бөмбөгдүүлж", түүндээ дасах хандлагатай болж иржээ.

Орчин үед төр засаг, нийгмийн тодорхой хэсэг бүлэгт асуулт тавих нэлээд өргөн боломж, орон зай бий болж, ийм эрхийг гол төлөв сэтгүүлчид эдэлж, ОНМХ олон нийтийн үзэл бодлын индэр болон хувирч байна. Олон нийтийн санал бодол ардчиллын оршин тогтох үндэс болж, төр засгийн өөрийн байр суурийг хадгалахад түшиглэх гол нөхцөл, боломж болдгоороо чухал ач холбогдолтой.

Бид ХХ зууныг "мэдээллийн зуун" хэмээн нэрийдэж байсан бол өнөөдрийн бидний амьдарч буй ХХI зуун "мэдлэгийн зуун" болох учиртай. Олон нийт мэдээллийн далайд живэх шахсан энэ үед мэдлэг бүтээх, тэдний амьдралд хэрэг болохуйц чанартай мэдээллээр хангах цаг нэгэнт болжээ. Тиймээс Монголын сэтгүүлч, судлаачид дараах асуудалд анхаарлаа хандуулах болсон буй за. Үүнд:

- Сэтгүүлч, ярилцагч хоёр хувийн ашиг хонжоо хөөцөлдөн, зорилгоосоо

хазайж, сониныг сурталчилгааны талбар болгохгүй байх.

- Ярилцлагын бичлэгийн ур чадвар, мэдээллийн багтаамжийг сайжруулж, үр нөлөөг дээшлүүлэх. Өөрөөр хэлбэл тооноос чанарт шилжих.

- Ярилцагчийг иргэний нийгмийн төлөөллөөс түлхүү сонгож, ярилцлагын сэдвийн цар хүрээг өргөн болгох (зөвхөн улс төрийн лидер, урлаг, соёлын од гэх мэт цөөн тооны хүмүүсээр хязгаарлахгүй байх).

- Иргэдийн боловсрол, үзэл бодлын төлөвшилд анхааран, нийгэмсоёлын үнэт зүйлийн эрхэмлэлийг бий болгоход анхаарах.

- Ярилцлага нийгмийн удирдлагын судалгааны чухал объект байх ёстой.

- Сэтгүүлч өөрөө бүтээлч, судлаач, шинжээч байх.

- Ярилцлагаар дамжин олон түмэнд хүрч буй мэдээлэл монгол хэлний зөв найруулга бүхий, логикийн болон гоо зүйн алдаагүй асуулт, хариулт бүхий байх.

#### Ишлэл

<sup>1</sup> 2013. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. МХХ-гийн мониторингийн судалгаа. УБ., 1 дэх тал.

<sup>2</sup> «Шинэ толь хэмээх бичиг» сонин. 1914.08.21, №20.

<sup>3</sup> *Норовсүрэн Л.* 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ., 69 дэх тал.

<sup>4</sup> *Ясперс К.* 1991. Смысл и назначение истории. М.: Политиздат, с. 527.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Зулькафиль М., Норовсүрэн Л.* 2002. Ярилцлага. УБ.

2. *Норовсүрэн Л.* 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.

3. *Чойсамба Ч.* 2001. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл. УБ.

4. 2013. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. МХХ-гийн мониторингийн судалгаа. УБ.

5. «Шинэ толь хэмээх бичиг» сонин. 1914.08.21, №20.

6. *Ясперс К.* 1991. Смысл и назначение истории. М.: Политиздат.

7. *Тертычный А. А.* 2000. Жанры периодической печати. Учебное пособие. М.: Аспект Пресс.

#### Summary

Journalists play a role in the distribution of cultural norms and values that form the modern society. Nowadays, they have become not only information distributors, but also creators of social mind. Expression of own ideas through mass media has become a tool to influence on formation of public psychology, to control and stand against state and governmental organization's breaches and misuse of power. When social relations move the principle of majority and an individual becomes able to address the majority through interview, individuals have more influences and participation in environmental, social, economic, political, and cultural relations thereby making changes in life habits of people. In other words, interview in mass media has become an integral part of human life and played an important role in creation of political leadership, personal formation, and tendency of imitation and assimilation.